



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

СБА-2022/85/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт сум

2022 он

Тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 70518369

Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 70512123

Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитор:

А.Мөнхцэцэг

Утас: 70512127

Цахим хаяг: Munkhtsetsega@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.1 Зөвлөмж.....	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

Хөдөл.Орл.дс № 89

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ч.АЛТАННАВЧ
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>87,064,073.41</u>	<u>79,772,748.53</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	87,064,073.41	79,772,748.53
351	Түүхий эд материал	2,852,095.00	00.00
35130	Эм боох материал	2,852,095.00	00.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	11,385,150.50	11,385,150.50
354	Хангамжийн материал	72,826,827.91	68,387,598.03
35410	Бичиг хэргийн материал	317,404.00	157,553.00
35420	Аж ахуйн материал	10,819,627.00	10,761,997.00
35440	Түлш, шатах тослох материал	240,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	12,031,900.00	00.00
35460	Хүнсний материал	00.00	124,006.00
35470	Бусад хангамжийн материал	49,417,896.91	57,344,042.03
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,315,369,920.29</u>	<u>1,292,441,654.73</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,315,369,920.29	1,292,441,654.73
392	Биет хөрөнгө	1,188,189,920.29	1,165,261,654.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,168,343,827.00	1,168,343,827.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-62,723,858.64	-94,085,787.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	158,680,352.00	177,038,302.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-133,081,928.48	-141,563,180.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	142,938,279.00	145,108,279.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-122,069,941.59	-128,765,480.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,888,500.00	1,888,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,007,200.00	-1,384,900.00
39217	Ном	35,221,891.00	38,682,094.88
393	Биет бус хөрөнгө	127,180,000.00	127,180,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	127,180,000.00	127,180,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,402,433,993.70</u>	<u>1,372,214,403.26</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,402,433,993.70</u>	<u>1,372,214,403.26</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,402,433,993.70	1,372,214,403.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	152,616,000.00	152,616,000.00
51101	Өмч: - төрийн	152,616,000.00	152,616,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,170,977,233.89	1,140,757,643.45
51210	Өмнөх үеийн үр дүн	1,170,977,233.89	1,170,977,233.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	78,840,759.81	78,840,759.81
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,402,433,993.70</u>	<u>1,372,214,403.26</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,305,887,106.50	1,286,458,544.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,522,206.50	22,517,829.00
120	Нийтлэг татварын бус орлого	23,522,206.50	22,517,829.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,522,206.50	22,517,829.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	23,522,206.50	22,517,829.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	203,811,400.00	210,067,215.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,078,553,500.00	1,053,873,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,527,200.00	12,968,615.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	270,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	672,000.00	8,760,815.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,855,200.00	3,937,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	190,284,200.00	197,098,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	190,284,200.00	197,098,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,324,099,510.18	1,316,678,134.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,324,099,510.18	1,316,678,134.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,248,268,708.13	1,282,710,439.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	867,598,910.95	888,893,898.86
210101	Үндсэн цалин	580,399,893.63	605,939,116.19
210102	Нэмэгдэл	212,086,948.58	209,444,200.00
210104	Урамшуулал	75,112,068.74	73,510,582.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,560,518.00	113,925,500.00
210201	Тэтгэврийн даатгал	72,811,718.00	73,814,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,937,200.00	17,388,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,149,800.00	6,059,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,787,400.00	1,514,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,874,400.00	15,148,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	168,639,360.00	182,098,600.00
210301	Гэрэл, цахилгаан	5,210,824.00	4,578,117.00
210302	Түлш, халаалт	154,522,060.00	165,558,677.00
210303	Цэвэр, бохир ус	8,906,476.00	11,961,806.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,569,245.00	9,299,526.00
210401	Бичиг хэрэг	963,700.00	1,742,596.00
210402	Тээвэр, шатахуун	2,710,000.00	846,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,540,300.00	1,999,700.00
210404	Ном, хэвлэл	6,803,480.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	404,544.00	359,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,147,221.00	4,350,930.00
2105	Нормативт зардал	3,016,780.00	5,537,095.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,334,200.00	4,687,095.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,682,580.00	850,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,482,800.00	27,031,900.00
210604	Урсгал засвар	8,482,800.00	27,031,900.00
2107	Томилот, зочны зардал	242,000.00	00.00
210702	Дотоод албан томилот	242,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,341,240.00	4,507,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,341,240.00	4,507,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,817,854.18	51,416,619.44
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,696,717.00	4,500,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,121,137.18	46,916,419.44

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,830,802.05	33,967,695.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,016,956.00	33,536,305.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,565,500.00	1,313,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,451,456.00	32,222,905.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	431,390.14
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,135,588.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,135,588.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,678,258.05	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,678,258.05	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-18,212,403.68	-30,219,590.44
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-18,212,403.68	-30,219,590.44

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	152,616,000.00	78,840,759.81	1,189,132,555.66	1,420,589,315.47
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	152,616,000.00	78,840,759.81	1,189,132,555.66	1,420,589,315.47
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-18,212,403.68	-18,212,403.68
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	152,616,000.00	78,840,759.81	1,170,977,233.89	1,402,433,993.70
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	152,616,000.00	78,840,759.81	1,170,977,233.89	1,402,433,993.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	152,616,000.00	78,840,759.81	1,170,977,233.89	1,402,433,993.70
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-30,219,590.44	-30,219,590.44
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	152,616,000.00	78,840,759.81	1,140,757,643.45	1,372,214,403.26

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,286,755,546.00	1,263,940,715.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,286,755,546.00	1,263,940,715.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,078,553,500.00	1,053,873,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,527,200.00	12,968,615.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	270,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	672,000.00	8,760,815.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,855,200.00	3,937,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	190,284,200.00	197,098,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	190,284,200.00	197,098,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,390,646.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,390,646.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,249,485,927.95	1,254,418,835.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,249,485,927.95	1,254,418,835.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,206,172,580.95	1,220,327,133.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	866,848,910.95	888,893,898.86

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	579,649,893.63	605,939,116.19
210102	Нэмэгдэл	212,086,948.58	209,444,200.00
210104	Урамшуулал	75,112,068.74	73,510,582.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,560,518.00	113,925,500.00
210201	Тэтгэврийн даатгал	72,811,718.00	73,814,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,937,200.00	17,388,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,149,800.00	6,059,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,787,400.00	1,514,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,874,400.00	15,148,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	170,945,812.00	182,098,600.00
210301	Гэрэл, цахилгаан	5,210,824.00	4,578,117.00
210302	Түлш, халаалт	156,828,512.00	165,558,677.00
210303	Цэвэр, бохир ус	8,906,476.00	11,961,806.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,429,040.00	9,340,535.00
210401	Бичиг хэрэг	1,222,100.00	1,675,115.00
210402	Тээвэр, шатахуун	3,924,000.00	606,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,540,300.00	1,999,700.00
210404	Ном, хэвлэл	6,883,240.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	742,500.00	359,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,116,900.00	4,699,420.00
2105	Нормативт зардал	7,374,300.00	2,685,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,372,300.00	1,835,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,002,000.00	850,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,514,700.00	15,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,311,900.00	00.00
210604	Урсгал засвар	13,202,800.00	15,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	242,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	242,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,933,500.00	4,507,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,933,500.00	4,507,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,323,800.00	3,876,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,323,800.00	3,876,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,313,347.00	34,091,701.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,177,759.00	33,660,311.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,390,646.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,565,500.00	1,313,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,221,613.00	32,346,911.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,135,588.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,135,588.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	431,390.14
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	431,390.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>37,269,618.05</u>	<u>9,521,880.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	591,360.00	9,521,880.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	591,360.00	9,521,880.00
2200	Дотоод эх үүсвэрээр	591,360.00	9,521,880.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	591,360.00	9,521,880.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-591,360.00</u>	<u>-9,521,880.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	36,678,258.05	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,251,578,500.00	1,251,147,109.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,251,578,500.00	1,251,147,109.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,217,811,800.00	1,217,486,798.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	889,218,900.00	888,893,898.86
210101	Үндсэн цалин	631,137,400.00	605,939,116.19

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210102	Нэмэгдэл	209,444,200.00	209,444,200.00
210104	Урамшуулал	48,637,300.00	73,510,582.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,925,500.00	113,925,500.00
210201	Тэтгэврийн даатгал	83,902,300.00	73,814,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,505,800.00	17,388,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,004,600.00	6,059,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,501,200.00	1,514,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,011,600.00	15,148,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,098,600.00	182,098,600.00
210301	Гэрэл, цахилгаан	8,536,200.00	4,578,117.00
210302	Түлш, халаалт	159,455,900.00	165,558,677.00
210303	Цэвэр, бохир ус	14,106,500.00	11,961,806.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,904,700.00	8,904,700.00
210401	Бичиг хэрэг	1,199,700.00	1,199,700.00
210402	Тээвэр, шатахуун	606,400.00	606,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,999,700.00	1,999,700.00
210404	Ном, хэвлэл	250,000.00	250,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	359,900.00	359,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,489,000.00	4,489,000.00
2105	Нормативт зардал	2,399,600.00	2,399,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,549,600.00	1,549,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	850,000.00	850,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	15,000,000.00
210604	Урсгал засвар	15,000,000.00	15,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,175,900.00	1,175,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	569,500.00	569,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	606,400.00	606,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5088600.00	5088600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,088,600.00	5,088,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33766700.00	33660311.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,766,700.00	33,660,311.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,313,400.00	1,313,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,453,300.00	32,346,911.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,250,972,100.00	1,250,972,100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,053,873,500.00	1,053,873,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,053,873,500.00	1,053,873,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	197,098,600.00	197,098,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	197,098,600.00	197,098,600.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	65	65
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	50	50
620003	Үйлчлэх ажилтан	14	14
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	861	861
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	861	861
630001	Төрийн өмчит ЕБС	861	861
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	65	65
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	46	46
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19	19

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,968,615.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,968,615.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,968,615.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,345,415.00
210401	Бичиг хэрэг	475,415.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,870,000.00
2105	Нормативт зардал	285,400.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	285,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,937,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,937,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5400000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,400,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12968615.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,968,615.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	270,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,760,815.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,937,800.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Суралцагчдын сурах үйлийг дэмжин сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил, төлөвшил, сурлагын амжилт, чанарт ахиц гаргана. Сурлага, Төлөвшил, Эрүүл мэндийн чиглэлээр нийт 9 зорилтыг дэвшүүлсэн байна.

Баруун-Урт сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургууль “Суралцагчдын сурах үйлийг дэмжин сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил, төлөвшил, сурлагын амжилт, чанарт ахиц гаргана” үндсэн зорилгыг дэвшүүлэн ажиллагаа явуулдаг Баруун-Урт сумын ТТЗ-ийн харьяа байгууллага юм.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 1,324.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 19.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 14.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 30.2 сая төгрөг буюу 2.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	87.0	79.8	-7.2
Үндсэн хөрөнгө	1,315.4	1,292.4	-23.0
Нийт хөрөнгө	1,402.4	1,372.2	-30.2
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,402.4	1,372.2	-30.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,402.4	1,372.2	-30.2

Бараа материалын дансны үлдэгдэл 79.8 сая төгрөг болж 7.2 сая төгрөгөөр буурсан байна. Бараа материал данс буурсан нь эхний үлдэгдлээс зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,292.4 сая төгрөг болж 23.0 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 9.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, бусад эх үүсвэрээс 14.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, ном худалдан авч элэгдлийн зардлаар буурсан нь нөлөөлжээ.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 19.4 сая төгрөг буюу 1.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт байна

Нийт зардал өмнөх оноос 7.4 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 182.4 сая төгрөгөөр бууруулж 1.245.7 сая төгрөгөөр баталсан байна. Харин төсвийн тодотголоор тус байгууллагын төсөв 5.2 сая төгрөгөөр нэмэгджээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,250.9 сая төгрөгийг улсын төсвөөс баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,250.9 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1.250.5 сая төгрөг зарцуулж 0.4 сая төгрөгийн төсвийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Баруун-Урт сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансаар 12.9 мянган төгрөгийг дамжуулан зарцуулсан байна. БШУЯ-наас “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд 8.0 сая, ГБХЗХГ 0.2 сая, Боловсролын газраас 0.8 сая, түрээсийн сурах бичгийн төлбөр 3.9 сая санхүүжилт төвлөрсөн байна.

Төслийн хүрээнд багш нар туршлага судлах, цахим хичээл бэлтгэх материаллаг баазаа нэмэгдүүлсэн, Ковид19 цар тахлын өвчлөлтэй холбогдуулан боловсролын газрын шийдвэрийн дагуу эм бэлдмэл, ариутгалын зардал зэрэг нийт 12.9 мянган төгрөгийн төлбөр тооцоог нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Баруун-Урт сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургууль гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 89 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилт нь 94.4 хувьтай үнэлэгдсэн байна.

Тайлант онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А\131, А\308 дугаар хамтарсан тушаалаар Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зорилготой “Хөдөлмөр сургалтын танхим” байгуулах төслийн уралдаанд шалгарч 15.0 сая төгрөгийн санхүүжилтийн тоног төхөөрөмж хүлээн авч сургалтын танхим байгуулсан.

Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд 8.0 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч “Унаган хэл-Ухаарахуйн хөтөч” төслийг амжилттай хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд багш нар туршлага судлах, цахим хичээл бэлтгэх материаллаг баазыг нэмэгдүүлсэн.

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байна

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Баруун-Урт сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуульд "Итгэл" үзүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын гуравдугаар сургуулийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4.0 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, үндсэн хөрөнгийн зардалтай холбоотой 1 асуудалд зөвлөмж өгсөн.

4.1 АЛБАН ШААРДЛАГА

Төсвийн хөрөнгөөр 4.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, ном худалдан авч төсвийн хэмнэлтийн горимыг зөрчсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/ Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 /энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;/ дахь заалтыг зөрчсөн байна.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 131 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баруун-Урт сумын гуравдугаар сургууль	2	4.0	-	-	-	-	1	4.0	1	-

